

**Mongolian language for foreigners - Week 3**  
**Lecture №3**

**Сэдэв: Монгол улсын төрийн бэлгэ тэмдэг**  
**Topic: Mongolian state symbol**

**Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх**  
**listening, speaking, reading, writing**

**Mongolian National University Arts And Culture**  
**Professor, Basbish.S**

## Хичээлийн агуулга - Lecture content

---

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монгол улсын төрийн бэлгэ тэмдэг - Mongolian state symbol
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and Homework

Мэдлэг шалгах тест - Test

1. Аливаа улсын төрийн эрх барих дээд байгууллага болон төрийн захиргааны дээд байгууллага байрладаг төв хотыг .....гэдэг.

А. Нийслэл

Б. Аймаг

В. Сум

Г. Дүүрэг

2. Монгол улсын нийслэл хотын түүх өндөр гэгээн .....салшгүй холбоотой.

А. Занабазартай

Б. Чингис хаантай

В. Жавзандамба хутагттай

Г. Сүхбаатартай

3. Одоогийн .....аймагт анх өндөр гэгээн Занабазарт зориулсан тусгай өргөө байгуулж өгсөн нь одоогийн нийслэл хотын суурь болсон.

А.Архангай

Б. Өвөрхангай

В. Дархан

Г. Эрдэнэт

4. Өндөр гэгээн Занабазарыг .....настай байхад нь түүнд зориулж тусгай өргөө байгуулж өгсөн нь одоогийн Улаанбаатар хотын суурь болсон.

А. 18

Б.3

В. 5

Г. 8

5. Улаанбаатар хот нь байгуулагдсан цагаасаа хойш.....удаа нүүсэн.

А. 7

Б. 10

В. 17

Г.71

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and Homework

Мэдлэг шалгах тест - Test

6. Улаанбаатар хот нийт .....дүүрэгтэй.

A. 6

Б. 3

В. 9

Г. 8

7. Улаанбаатар хот нь .....голын хөвөөнд оршдог.

А. Туул

Б. Сэлэнгэ

В. Орхон

Г. Буянт

8. Улаанбаатар хот далайн түвшнээс дээш.....өндөрт байрладаг.

A. 1000-1100м

Б. 1300-1500м

В. 1500-1600м

Г. 1800-2000м

9. Улаанбаатарт амьдарч байгаа хүн амын .....хүүхэд, залуучууд юм.

А. 60%

Б. 30%

В.90%

Г.80%

10. Улаанбаатар хот одоогийн нэрээрээ .....онд нэрлэгдсэн.

A. 1990

Б.1206

В. 1945

Г.1924

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3  
Mongolian state symbol lecture-3

---

*Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.*

1. Төрийн бэлгэ тэмдэг гэж юу вэ?
2. Төрийн бэлгэ тэмдэгт юу юу ордог вэ?
3. Монгол төрийн бэлгэ тэмдгүүдээс нэрлэнэ үү?
4. Монгол улсын төрийн сүлд харж байсан уу? Сүлдэн дээр юу юу дүрсэлсэн байдаг вэ?
5. Монгол улсын төрийн сүлд туг гэж юу вэ?

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 13)

# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3

## Mongolian state symbol lecture-3

Flag of Mongolia



Монгол улсын төрийн далбаа [Photograph]. (2019, February 1).  
<https://mfa.gov.mn/57971>

State [Emblem of Mongolia](#)



Монгол улсын төрийн сүлд [Photograph]. (2022, May 1). <https://mn.wikipedia.org/wiki/>

[%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB\\_%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD\\_%D1%82%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0](#)

[%BD\\_%D1%81%D2%AF%D0%BB%D0%B4#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:State\\_emblem\\_of\\_Mongolia.svg](#)

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words : 1686, арга билиг, гурвалжин, хөх, дугариг, тусгаар тогтнол, дөрвөлжин, соёмбо, гал, нар, сар*



Монгол улсын төрийн далбаа  
[Photograph]. (2019, February 1).  
<https://mfa.gov.mn/57971>


### МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ - I

**Төрийн далбаа:** Төрийн далбаа нь улаан, 1) хөх , улаан хосолсон өнгөтэй байдаг. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх хөх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байдаг. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт Монгол төрийн бэлгэ тэмдэг болсон алтан 2) соёмбо байрладаг. Далбааны өргөн, урт нь 1:2 хэмжээтэй байдаг.

# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3

## Mongolian state symbol lecture-3

*Нөхөх үгс - Choose from following words : 1686, арга билиг, гурвалжин, хөх, дугариг, тусгаар тогтнол, дөрвөлжин, соёмбо, гал, нар, сар*



Соёмбо [Photograph]. (2022, July 26). [https://mn.wikipedia.org/wiki/](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3)

[%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE\\_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3)

**Төрийн соёмбо:** 3)\_\_\_\_\_ онд Анхдугаар богд Занабазарын зохиосон Соёмбо үсгийн толгой үсгийг Монголчууд төрийн соёмбо болгосон. Соёмбо гэдэг нь “Өөрөө гарсан гэгээн” гэсэн утгатай санскрит үг бөгөөд улс төр, гүн ухаан, шашны олон бэлгэдлийг агуулдаг. Соёмбо үсгийг Лигдэн хааны үеэс Монгол улсын туг далбаан дээр 4)\_\_\_\_\_ \_\_\_\_\_, эв нэгдлийн бэлгэ тэмдэг болгон, мөн төрийн тамга, ном судрын толгой, сүм хийдийн уран барилгын чимэглэл болгон хэрэглэсээр иржээ.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 13)

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3  
Mongolian state symbol lecture-3

*Нөхөх үгс - Choose from following words : 1686, арга билиг, гурвалжин, хөх, дугариг, тусгаар тогтнол, дөрвөлжин, соёмбо, гал, нар, сар*



Соёмбо [Photograph]. (2022, July 26). [https://mn.wikipedia.org/wiki/](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3)

[https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE\\_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3)

Соёмбын хамгийн дээр байдаг “гурван үзүүртэй 5) \_\_\_\_\_” бол өнгөрсөн, одоо, ирээдүйн гурван цагт балчир, идэр, өтгөс гурван үеэрээ үүрд мандахын бэлгэдэл болдог. Түүний доор байгаа “6) \_\_\_\_\_, \_\_\_\_\_” хоёр бол мөнх тэнгэрийг төлөөлөн эгнэгт батжин бэхжих, энхжин мөнхжихийн бэлгэдэл юм. Энэхүү гал, нар, сар гурав нийлээд Монгол улс бадран мандах болтугай гэсэн утгыг бэлгэддэг.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 13)

**Нөхөх үгс - Choose from following words : 1686, арга билиг, гурвалжин, хөх, дугариг, тусгаар тогтнол, дөрвөлжин, соёмбо, гал, нар, сар**



Соёмбо [Photograph]. (2022, July 26). [https://mn.wikipedia.org/wiki/](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3)

[https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE\\_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3)

“7) \_\_\_\_\_ дүрс” бол жад, сумны гилбэрийг дүрсэлсэн бөгөөд үзүүрийг доош харуулсан нь дайсныг дарна гэсэн утгатай. Дээд гурвалжин нь дотоодын дайсныг, доод гурвалжин нь гадаадын дайсныг дарахыг бэлгэдсэн утгатай. Дээд гурвалжингийн доор, доод гурвалжингийн дээр байх “хэвтээ 8) \_\_\_\_\_ ” нь шулуун шударга, бат бөх журамтай байхыг бэлгэддэг. Голд байх “9) \_\_\_\_\_ дүрс” бол хос загасны дүрс. Загас өдөр ч шөнө ч нүдээ аньдаггүй мөн үр төл ихтэй амьтан тул Монголчууд сонор соргог, өнөр өтгөн байхыг бэлгэдэн дүрсэлсэн. Мөн энэ дүрс 10) \_\_\_\_\_ , \_\_\_\_\_ буюу эр, эм гэсэн утгатай.

Соёмбын хоёр хажуугийн “босоо дөрвөлжин” нь хэрмийг дүрсэлсэн тэмдэг. Энэ нь Монголын бүх ард түмэн эх орныхоо төлөө эв сэтгэл нэгтэй бол төмөр хэрэмнээс ч бат бөх гэсэн утга санааг хадгалжээ. Ийнхүү “Соёмбо тэмдэг” нь “Монголын ард түмэн гал мэт мандан бадарч, наран саран мэт гэрэлтэн мөнхжиж, сум мэт цэх шулуун, хуяг мэт бат бэх, загас мэт сонор соргог, өнөр өтгөн болж, арга, билгээ хослон төмөр хэрэм лугаа адил төр улсаа хамгаалъя” гэсэн гүн утга илэрхийлдэг.



Соёмбо [Photograph]. (2022, July 26). [https://mn.wikipedia.org/wiki/](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3)

[https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE\\_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3)

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 14)

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3  
Mongolian state symbol lecture-3

---

*Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.  
Exercise 3. Discuss about following questions and review your understanding*

1. Монгол төрийн далбаанд ямар ямар өнгө орсон байдаг вэ?
2. Төрийн далбааны өнгөнүүд юуг бэлгэддэг вэ?
3. Төрийн далбаан дээр юуны дүрс байдаг вэ? Юуг бэлгэддэг вэ?
4. Соёмбыг хэн зохиосон бэ? Хэзээнээс Монгол төрийн бэлгэ тэмдэг болгон хэрэглэж байгаа вэ?
5. Соёмбон дээрх гал юуг бэлгэддэг вэ?

## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3

### Mongolian state symbol lecture-3

---

*Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.*

*Exercise 3. Discuss about following questions and review your understanding*

1. Соёмбон дээрх нар, сар юуг бэлгэддэг вэ?
2. Соёмбон дээрх гурвалжин дүрснүүд юуг бэлгэддэг вэ?
3. Соёмбон дээрх хэвтээ дөрвөлжин дүрснүүд ямар утгатай вэ?
4. Соёмбон дээрх босоо дөрвөлжин нь ямар утгатай вэ?
5. Соёмбоны голд байдаг бөөрөнхий дүрс юу вэ? Юуг бэлгэддэг вэ?

**Дасгал 4. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.**  
**Exercise 4. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words : соёмбо, 1950, 1206, төрийн ордонд, бадамлянхуа, ерөнхийлөгч, зандан, хүрдийг**

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ – II

**Төрийн сүлд:** Цэвэр ариуныг бэлгэдсэн цагаан өнгийн 1) бадамлянхуа цэцгэн суурьтай, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй. Хөх дэвсгэрийг төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэхийн бэлгэдэл түмэн насан хээгээр хүрээлсэн байдаг. Сүлдний төв хэсэгт Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг илтгэсэн алтан 2) соёмбо, цог хийморийг илтгэсэн эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн. Сүлдний хүрээний магнай хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, хөгжин дэвжихийг бэлгэдсэн 3) хүрдийг тус тус дүрсэлсэн. Хүрдийг дээдлэн хадгаар сүлжсэн байна.



Монгол улсын төрийн сүлд [Photograph]. (2022, May 1). [https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB\\_%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD\\_%D1%82%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD\\_%D1%81%D2%AF%D0%BB%D0%B4#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:State\\_emblem\\_of\\_Mongolia.svg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD_%D1%82%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%81%D2%AF%D0%BB%D0%B4#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:State_emblem_of_Mongolia.svg)

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3  
Mongolian state symbol lecture-3

*Нөхөх үгс - Choose from following words : соёмбо, 1950, 1206, төрийн ордонд, бадамлянхуа, ерөнхийлөгч, зандан, хүрдийг*

**Төрийн сүлд туг:** Цагаан зүсмийн адууны хялгасаар хийдэг учир “Цагаан сүлд” хэмээн нэрлэжээ. Монголчууд 4) \_\_\_\_\_ онд Чингис хааныг Их Монгол Улсын хаан ширээнд өргөмжлөхдөө есөн хөлт Цагаан туг босгож, их эзэн хаан туг сүлдэндээ мөргөн ёсолж байжээ.



Төрийн 9 хөлт цагаан туг [Photograph]. (2014, July 7). <https://ikon.mn/n/8gx>

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 19)

***Нөхөх үгс - Choose from following words : соёмбо, 1950, 1206, төрийн ордонд, бадамлянхуа, ерөнхийлөгч, зандан, хүрдийг***

Энэ үеэс Цагаан туг нь Монгол улсын төр мөнхөд мандан бадарч, төр улс, түмэн олон амар төвшин аж төрөхийн бэлгэдэл болон 5)\_\_\_\_\_ залагдсаар иржээ. Уг сүлдний орой дээр нь алтан шармал төмрөөр урласан гал бүхий 3 үзүүрт ган сэрээтэй, түүний доорхи дугираг царнаас цагаан хялгасыг 81 нүхнээс нарийхан зүссэн сураар бэхэлж унжуулсан байдаг. Цагаан туг нь гол сүлд болон түүний тойрсон есөн элч сүлдээс бүрддэг тул есөн хөлт цагаан туг хэмээн нэрлэжээ.



Төрийн 9 хөлт цагаан туг [Photograph].  
(2014, July 7). <https://ikon.mn/n/8gx>

## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3

### Mongolian state symbol lecture-3

*Нөхөх үгс - Choose from following words : соёмбо, 1950, 1206, төрийн ордонд, бадамлянхуа, ерөнхийлөгч, зандан, хүрдийг*

**Төрийн тамга:** Төрийн тамгыг Монгол Улсын 6) \_\_\_\_\_ барина. Төрийн тамга нь дөрвөлжин хэлбэртэй, голдоо Төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байна. Төрийн тамгыг цул мөнгөөр, гар аргаар, ганц хувь үйлдэнэ. Төрийн тамгыг үндэсний хээгээр чимэглэсэн мөнгөн тоног бүхий, зөөлөн торгомсог эдээр доторлосон 7) \_\_\_\_\_ модон хайрцагт байрлуулна.



Болортуяа, Ч. (2014, January 16). Төрийн тамга [Photograph]. <https://ikon.mn/n/> 304

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 20)

**Нөхөх үгс - Choose from following words : соёмбо, 1950, 1206, төрийн ордонд, бадамлянхуа, ерөнхийлөгч, зандан, хүрдийг**

**Төрийн дуулал:** Монгол улсын төрийн дуулал нь 8) \_\_\_\_\_ онд зохиогдсон бөгөөд аяыг Л.Мөрдорж, Б.Дамдинсүрэн нар зохиож, үгийг Ц.Дамдинсүрэн бичжээ. Төрийн дууллын шүлэг нь:

Дархан манай тусгаар улс  
Даяар монголын ариун голомт  
Далай их дээдсийн гэгээн үйлс  
Дандаа энхжин үүрд мөнхөжнө  
Хамаг дэлхийн шударга улстай  
Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж  
Хатан зориг бүхий чадлаараа  
Хайртай монгол орноо мандуулъя.

Өндөр төрийн минь сүлд ивээж  
Өргөн түмний минь заяа түшиж  
Үндэс язгуур, хэл соёлоо  
Үрийн үрдээ өвлөн бадраая  
Эрэлхэг монголын золтой ардууд  
Эрх чөлөө жаргалыг эдлэв  
Жаргалын түлхүүр, хөгжлийн тулгуур  
Жавхланта манай орон мандтугай.



(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 20)

Лхам, Б. (2018, November 2). Төрийн дуулал [Photograph]. <https://www.24tsag.mn/a/166999>

***Дасгал 5: Тохирох үгийн доогуур зурна уу.***

***Exercise 5: Underline the appropriate word.***

1. Соёмбо үсгийг Лигдэн хааны үеэс Монгол улсын туг далбаан дээр .....  
(хэрэглэж байна, хэрэглэдэг, хэрэглэж байсан)
2. Монгол Улсын төрийн байгууллагуудын тамга тэмдэг дээр соёмбыг .....  
(байрлуулдаг, байрлуулж байна, байрлуулж байгаа)
3. Т.Төмөрсүх дархан яг одоо алт болон гуулиар маш том соёмбо .....  
(хийж байна, хийдэг, хийж байгаа)
4. 2021 оны 02-р сарын 19-ний өдрийн байдлаар “СОЁМБО” гэсэн нэртэй 1100 хүн .....  
(амьдарч байна, амьдардаг, амьдарч байгаа)

*Дасгал 5: Тохирох үгийн доогуур зурна уу.*

*Exercise 5: Underline the appropriate word.*

5. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо .....
- (байрлаж, байрлаж байна, байрладаг, байрлаж байгаа)
6. Төрийн далбааг Монгол Улсын Төрийн ордон, Монгол Улсын ерөнхийлөгчийн өргөө зэрэг газар байнга .....
- (байрлуулж байна, байрлуулдаг, байрлуулж байгаа)
7. Өнөөдөр 7 дугаар сарын 10-ны өдөр. Энэ өдөр Төрийн далбааны өдөр.....
- (тохиож байна, тохиодог, тохиож байгаа)
8. Уг өдрийг 2008 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн .....
- (тэмдэглэж байна, тэмдэглэдэг, тэмдэглэж байгаа)

*Дасгал 6: Дараах үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээгээрэй.*

*Exercise 6: Underline the appropriate word.*

*Хадгаар, хээгээр, хялгасаар, сураар, мөнгөөр, аргаар, модоор, торгоор*

**хээгээр**

1. Монгол улсын Төрийн сүлдийг түмэн насан .....хүрээлсэн байдаг.
2. Есөн хөлт тугийг цагаан адууны .....хийдэг учраас “Цагаан туг” хэмээдэг.
3. Төрийн тамгыг цул мөнгөөр, гар ..... ганц хувь хийх ёстой.
4. Төрийн тамганы хайрцгийг .....чимэглэж, .....тодорлодог.
5. Тугийг цагаан хялгасыг нарийн.....бэхэлж унжуулсан байдаг.
6. Хүрдийг дээдлэн.....сүлжсэн байна.
7. Төрийн тамганы хайрцгийг анхилам үнэрт, хатуу чанарын мод болох зандан.....хийдэг.

*Дасгал 7. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.*

*Exercise 7. Discuss about following questions and review your understanding*

1. Монгол улсын төрийн сүлдэн дээр юу юуг дүрсэлсэн байдаг вэ?
2. Төрийн сүлд ямар бэлгэдэлтэй вэ?
3. Төрийн есөн хөлт цагаан тугийг юугаар хийдэг вэ?
4. Төрийн есөн хөлт цагаан туг нь ямар бэлгэдэлтэй вэ?

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3  
Mongolian state symbol lecture-3

---

***Дасгал 7. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.  
Exercise 7. Discuss about following questions and review your understanding***

1. Төрийн сүлд тугийг хаана залдаг вэ?
2. Төрийн тамгыг дүрсэлнэ үү?
3. Төрийн тамгыг хэн барьдаг вэ?
4. Төрийн дууллын үг, аяыг хэн зохиосон бэ?
5. Төрийн дуулал хэзээ зохиогдсон бэ?

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 20)

## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3

### Mongolian state symbol lecture-3

---

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.*


*Memorize the new vocabularies and understand the meaning*

1. *Арга билиг – yin-yang*
2. *Бат бөх журам- firm discipline*
3. *Бэлгэдэл - symbol*
4. *Бэлгэ тэмдэг - emblem*
5. *Өнөр өтгөн – having many children and relatives*
6. *Сонор соргог - cautious*
7. *Сонор сэрэмжтэй байх –to look out*
8. *Төрийн далбаа – national flag*
9. *Төрийн тамга – state seal*
10. *Туг далбаа - flag*
11. *Тусгаар тогтнол - independence*
12. *Хэрэм - wall*
12. *Улс төр*
13. *уран барилга*
14. *эв нэгдэл*
15. *адууны хялгас – hair of horses*
16. *их эзэн хаан – the Great Emperor*
17. *дугариг - circle*
18. *хадаг – traditional ceremonial scarf*
19. *хөгжин дэвжих – to flourish*
20. *түг сүлд - banner*
21. *хүрд - wheel*
22. *хүрээ - frame*
23. *цог хийморь – good fortune, spirit*

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3  
Mongolian state symbol lecture-3

---

Гэрийн даалгавар 1  
Homework 1



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.
- Memorize the new vocabularies and understand the meaning

# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3


## Mongolian state symbol lecture-3

### Гэрийн даалгавар 2

### Homework 2



Үгийн сүлжээг бөглөнө үү.



#### Хөндлөн

1. Улаанбаатар хот нь ямар голын хөвөөнд оршдог вэ?
2. Монгол улс аль тивд оршдог вэ?
3. Монгол улсын хамгийн өндөр цэг юу вэ?
4. Монгол улсын төрийн далбаан дээрх соёмбо ямар өнгөтэй вэ?
5. Соёмбон дээрх босоо дөрвөлжин юуг дүрсэлдэг вэ?

#### Босоо:

1. Монгол улсын хүн амын 80 гаруй хувийг ямар үндэстэн эзэлдэг вэ?
2. Аливаа улсын төрийн эрх барих дээд байгууллага болон төрийн захиргааны дээд байгууллага байрладаг төв хотыг юу гэж нэрлэдэг вэ?
3. Монгол улсын нийслэл хот юу вэ?
4. Монгол улсын төрийн тэргүүнийг юу гэж нэрлэдэг вэ?
5. Аль аялгуу нь орчин цагийн монгол утга зохиолын хэлний суурь болдог вэ?

# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3

## Mongolian state symbol lecture-3

---

### Гэрийн даалгавар 2

### Homework 2



Үгийн сүлжээг бөглөнө үү.

#### Хөндлөн

1. Улаанбаатар хот нь ямар голын хөвөөнд оршдог вэ?
2. Монгол улс аль тивд оршдог вэ?
3. Монгол улсын хамгийн өндөр цэг юу вэ?
4. Монгол улсын төрийн далбаан дээрх соёмбо ямар өнгөтэй вэ?
5. Соёмбон дээрх босоо дөрвөлжин юуг дүрсэлдэг вэ?

#### Босоо:

1. Монгол улсын хүн амын 80 гаруй хувийг ямар үндэстэн эзэлдэг вэ?
2. Аливаа улсын төрийн эрх барих дээд байгууллага болон төрийн захиргааны дээд байгууллага байрладаг төв хотыг юу гэж нэрлэдэг вэ?
3. Монгол улсын нийслэл хот юу вэ?
4. Монгол улсын төрийн тэргүүнийг юу гэж нэрлэдэг вэ?
5. Аль аялгуу нь орчин цагийн монгол утга зохиолын хэлний суурь болдог вэ?

# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ ЛЕКЦ-3

## Mongolian state symbol lecture-3

### Гэрийн даалгавар 3

### Homework 3



### Мэдлэг шалгах тест - Test

**1. Монгол улсын төрийн далбаанд ямар ямар өнгө орсон байдаг вэ?**

- А. Улаан, хөх, шар      б. Улаан, ногоон, хөх      в. цагаан, хөх, ногоон      г. улаан, цагаан, ягаан

**2. Монгол улсын төрийн далбааны улаан өнгө ямар бэлгэдэлтэй вэ?**

- А. Нар      б. Мандан бадрах      в. Мөнх тэнгэр      г. Амгалан тайван байх

**3. Монгол улсын төрийн далбааны хөх өнгө ямар бэлгэдэлтэй вэ?**

- А. Нар      б. Мандан бадрах      в. Мөнх тэнгэр      г. Амгалан тайван байх

**4. Төрийн соёмбыг хэн зохиосон бэ?**

- А. Чингис хаан      б. Жавзандамба хутагт      в. Занабазар      г. Д.Сүхбаатар

**5. Соёмбо гэдэг нь “өөрөө гарсан гэгээн” гэсэн утгатай .....үг.**

- А. Монгол      б. Санскрит      в. Төвөд      г. Энэтхэг

Гэрийн даалгавар 3   
Homework 3

Мэдлэг шалгах тест - Test

1. Монгол төрийн сүлд нь .....бэлгэдсэн цагаан өнгийн бадамлянхуа цэцгэн суурьтай.

А. Цэвэр ариуныг                      б. Амар амгаланг                      в. Гоо үзэсгэлэнг                      г. Сайхан сэтгэлийг

2. Монгол төрийн сүлд нь .....бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй.

А. Гол мөрнийг                      б. Мөнх тэнгэрийг                      в. Эх дэлхийг                      г. цэцгийг

3. Монгол төрийн сүлдийг мөнхөд үргэлжлэн дэлгэрэхийн бэлгэдэл.....хээгээр хүрээлсэн байдаг.

А. Хаан сүйх                      б. Хатан сүйх                      в. Түмэн насан                      г. Үүлэн

4. Монгол төрийн сүлдэн дээр тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэлгэдэн алтан.....дүрсэлсэн байдаг

А. гардийг                      б. нарыгф                      в. загасыг                      г. соёмбыг

5. Монгол төрийн сүлдэн дээр ..... бэлгэдэн, эрдэнийн хүлгийг дүрсэлсэн байдаг.

А. Энх тайвныг                      б. Арга ухааныг                      в. Цог хийморийг                      г. Хурд хүчийг

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

---

### Ном зүй

Ариунжаргал, Г. (2008). Монгол хэлний зөв бичих зүйн дүрэм ба дасгал .

Улаанбаатар: ТЗҮААЭГ-ын харьяа хэвлэх үйлдвэр.

Мөнхцэцэг, Г., Орхон, Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Монгол улсын төрийн далбаа [Photograph]. (2019, February 1).

<https://mfa.gov.mn/57971>

Монгол улсын төрийн сүлд [Photograph]. (2022, May 1).

<https://mn.wikipedia.org/wiki/>

%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB\_%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD\_%D1%82%D3%A9%  
D1%80%D0%B8%D0%B9%D0  
%BD\_%D1%81%D2%AF%D0%BB%D0%B4#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:State\_emblem\_of\_Mongolia.svg

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

---

Соёмбо [Photograph]. (2022, July 26).

<https://mn.wikipedia.org/wiki/>

%D0%A1%D0%BE%D1%91%D0%BC%D0%B1%D0%BE\_%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3

Төрийн 9 хөлт цагаан туг [Photograph]. (2014, July 7).

<https://ikon.mn/n/8gx>

Болортуяа, Ч. (2014, January 16). Төрийн тамга [Photograph].

<https://ikon.mn/n/304>

Лхам, Б. (2018, November 2). Төрийн дуулал [Photograph].

<https://www.24tsag.mn/a/166999>

# Анхаарал хандуулсанд баярлалаа


**Онъсого**

*Мэддэгт мэргэн цоохор  
Мэддэггүйд эрэн цоохор*

**Дараагийн хичээл хүртэл  
баяртай!**



[https://www.flaticon.com/free-icon/teacher\\_1995413](https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413)



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>